

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийтлэг-Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Ариунзул Утас: 70512127
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
Байгууллагын үйл ажилагаа	9
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	12
4.2.2 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.СҮМЬЯА ТАНАА

№ 22.03.16 № 144
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын зорилтот түвшин, ашиг орлогын хуваарилалт, төлөвлөгөөг батлуулаагүй, өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, тооллогоор хөрөнгө дутсан, санхүүгийн тайлан зөрүүтэй, өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 01-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	219,391.46	3,195,019.58
1.1.2	Дансны авлага	50,967,474.00	45,605,322.00
1.1.6	Бараа материал	35,182,758.48	35,182,758.48
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	86,369,623.94	83,983,100.06
1.2.1	Үндсэн хөрөнгө	53,568,686.93	15,498,144.55
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	53,568,686.93	15,498,144.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	139,938,310.87	99,481,244.61
2.1.1.1	Дансны өглөг	28,128,174.00	18,487,725.00
2.1.1.3	Татварын өр	22,626,607.90	22,873,170.90
2.1.1.4	НДШ - ийн өглөг	11,624,976.10	3,041,174.77
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	62,379,758.00	44,402,070.67
2.2	Өр төлбөрийн нийт дүн	62,379,758.00	44,402,070.67
2.3.1	Өмч: - төрийн	329,690,240.18	329,690,240.18
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(252,131,687.31)	(274,611,066.24)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	77,558,552.87	55,079,173.94
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	139,938,310.87	99,481,244.61

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	427,687,406.79	366,849,073.00
3	Нийт ашиг (алдагдал)	427,687,406.79	366,849,073.00
4	Түрээсийн орлого	0.00	400,000.00
6	Ногдол ашгийн орлого	7,603.29	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	426,838,177.78	359,256,747.30
12	Бусад зардал	3,754,056.00	28,096,364.63
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,897,223.70)	(20,104,038.93)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,897,223.70)	(20,104,038.93)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(2,897,223.70)	(20,104,038.93)
24	Орлогын нийт дүн	(2,897,223.70)	(20,104,038.93)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	НИЙТ ДҮН
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	329,690,240.18	0.00	0.00	0.00	0.00	0.00	(252,131,687.31)	77,558,552.87
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(22,479,378.93)	(22,479,378.93)
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	329,690,240.18	0.00	0.00	0.00	0.00	0.00	(274,611,066.24)	55,079,173.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	404,978,129.50	372,611,225.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	62,451,591.50	29,457,150.00
	Татаас, санхүүжилтын орлого	342,288,487.00	333,478,473.00
	Бусад мөнгөн орлого	238,051.00	9,675,602.00
1.2	Мөнгөн зарлага (-)	405,325,848.89	369,085,596.88
	Ажиллагчдад төлсөн	234,267,618.00	214,344,236.74
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	60,834,217.06	73,243,566.31
	Бараа материал худалдан авахад төлсөн	76,373,310.00	51,931,190.00
	Ашиглалтын зардалд төлсөн	80,791.52	7,922,457.83
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,313,050.00	1,505,300.00
	Татварын байгууллагад төлсөн	3,262,867.76	12,215,971.00
	Бусад мөнгөн зарлага	27,193,994.55	7,922,875.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(347,719.39)	3,525,628.12
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,883,603.29	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	7,876,000.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	7,603.29	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,881,000.00	550,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	350,000.00	550,000.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	7,531,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,603.29	(550,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(345,116.10)	2,975,628.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,120,808.56	219,391.46
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	219,391.46	3,195,019.58

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар Нийтлэг үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө, өр төлбөр, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ нь “Аймгийн Засаг даргын болон Нутгийн удирдлагын ордонд ажилладаг төрийн албан хаагчдын шаардлагад нийцсэн нийтлэг үйлчилгээг явуулж, тэдгээрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах хангалт хийх” зорилт дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Тус байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 369.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажилагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар нийтлэг үйлчилгээ аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмчлөлд эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-н дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурлын заал, лед дэлгэц болон урсдаг самбарын үйлчилгээ
- Цэвэрлэгээ үйлчилгээ
- Цахилгаан хангамжийн үйлчилгээ
- Дулаан болон усан хангамжийн үйлчилгээ
- Харуул хамгаалалтын үйлчилгээ
- Хувцасны өлгүүрийн үйлчилгээ
- Засварын үйлчилгээ
- Автомашин жолоочийн үйлчилгээ
- Шуудан хэвлэлийн үйлчилгээ
- Гадаад дотоод зочинд үйлчлэх үйлчилгээ /Зочид төлөөлөгчдийн ажиллах нөхцөл, байр хоол зэрэг үйлчилгээг хариуцаж зохион байгуулах
- Ёслол хүндэтгэлийн чанартай үйл ажиллагаа /Хурал цуглааны бэлтгэл ажил, Улсын баяр наадам, Цагаан сар гэх мэт баярын үйлчилгээний ажлыг зохион байгуулах
- Мөн зочид буудал, цайны газар, фитнесс, лед дэлгэц, урсдаг самбарт мэдээлэл байршуулах зэрэг үйлчилгээнүүдийн хэвийн үйл ажиллагааг ханган орлогын эх үүсвэр бий болгон ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ

г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоогоор 29 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 29 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 1.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.2	3.1	2.9
Авлага	50.9	45.6	-5.3
Бараа материал	35.1	35.1	0
Үндсэн хөрөнгө	53.5	15.4	-38.0
Нийт хөрөнгийн дүн	139.9	99.4	-40.4
Өр төлбөрийн дүн	62.3	44.4	-17.9
Эздийн өмч	77.5	55.0	-22.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	139.9	99.4	-40.4

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 3.0 сая, харилцах дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 44.4 сая төгрөг болж 18.0 сая буюу 29 хувиар төгрөгөөр буурсан байна. Үүнд нийгмийн даатгалын хэлтэст өмнөх оны өглөгөөс 8.6 сая төгрөг, 2018, 2019 оны үлдэгдэл 10.5 сая төгрөгийг тус тус төлж барагдуулсан байна. Тайлант онд 1.7 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдэж, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Авлагын дансны үлдэгдэлд Шүүхийн шийдвэрээр эцсийн байдлаар шийдэгдсэн боловч төлөгдөөгүй 43.0 сая, 2021 оны буудлын орлого тооцоо нийлсэн актаар баталгаажуагүй 2.2 сая төгрөгийн авлага эзэлж байна.

Мөн 53.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө данс нь тайлант онд элэгдлийн зардлаар буурсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 77.5 сая төгрөг болж 27.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр буурсан.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "к"-д заасны дагуу Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-н захирал нь

байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалтыг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-н 2020 оны санхүүгийн тайланд аудит хийхэд байгууллагын зорилтот түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, санхүүжилтийг батлуулаагүй зөрчил дутагдал илэрч албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Нийт орлого 2020 онтой харьцуулахад 2021 онд 50.6 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар буурсан байна. Орлого буурсан шалтгаан нь АЗДТГ-аас хуваарилсан санхүүжилт буурсан болон Ковид-19 цар тахлын үед хол хорио тогтоосонтой холбоотой байна.

Гүйцэтгэлээр 366.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 387.2 сая төгрөгийн зардал гарган, 20.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь орлогын тайланд бусад зардалд 28.0 сая төгрөгийн зардал /тодорхойгүй/ байгаа нь нөлөөлсөн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал үүсээгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлж буй нь Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй, тооллогоор хөрөнгө дутсан, өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Мөн Орлогын тайлангийн татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/ нь Өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/-ын мөнгөн дүн зөрүүтэй илэрхийлэгдсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Сүхбаатар Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 140 мэдээллээс 78 мэдээллийг мэдээлж, 62 мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	5.2	-	-	0
Албан шаардлага	3	2.9	2	2.8	66.7
Зөвлөмж	2	-	-	-	0
Нийт дүн	6	8.1	2	2.8	34.5

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө болох 26.0 сая төгрөгийн автомашин, 110.2 сая төгрөгийн Тоглоомын талбай, 49.8 сая төгрөгийн Оранж шугам зэрэг нь тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй байна. Уг хөрөнгийг зохих дансанд бүртгэж санхүүгийн тайланд тусгах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 423.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 8.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх холбоотой 4 зөвлөмж хүргүүлээ.

4.2.1 Албан шаардлага:**1.1 Илрүүлэлт:**

Эд хөрөнгийн тооллого явуулахад биетээр байхгүй 5.6 сая төгрөгийн 3 ширхэг хөрөнгө дутуу тоологдсон зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Хөрөнгө төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.3 “эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.4 “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ”, 73.2 “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.” дахь заалт болон “оршин байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

1.2 Илрүүлэлт

Тайлант онд үүссэн 2.6 сая төгрөгийн өр төлбөр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, 20 дугаар зүйлийн 2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт болон “оршин байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.2.2 Зөвлөмж**1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 221 ширхэг 228.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2.Шилэн данстай холбоотой асуудал**2.2 Илрүүлэлт:**

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 140 мэдээллийг ил тод байршуулахаас 62 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

2.3 Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Тайлант онд үүссэн 1.3 сая төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4.3-т "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт болон "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3 Өгсөн зөвлөмж:

Тайланд тусгаагүй тус өр төлбөрийг холбогдох хуулийн дагуу данс бүртгэлд тусгаж, хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

2.4 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Үндсэн хөрөнгө болох 26.0 сая төгрөгийн автомашин, 110.2 сая төгрөгийн Тоглоомын талбай, 49.8 сая төгрөгийн Оранж шугам, нийт 186.0 сая төгрөгийн хөрөнгө тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" заалт болон "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.4 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд данс бүртгэлийг үнэн зөв илэрхийлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТГ	6	423.6					2	8.2	4	415.4
Дүн		6	423.6					2	8.2	4	415.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Дүн											
Нийт дүн											